

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/412/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Дарга, Тэргүүлэх аудитор	Г.Нандинжаргал
	Утас: 70007734	Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn
	Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер	
		Х.Түвшинбаяр
	Утас: 327734	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер:	Я.Алтанцэцэг
	Утас: 315093	Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn
Ахлах аудитор:	Д.Мөнхдэлгэр	
	Утас: 325093	Цахим хаяг: munkhdelgerd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соблын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 387
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
Ч.БАЙГАЛЬ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 674.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллага нь дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 1,468.9 сая төгрөгийн төсөв баталж, салбар зөвлөлд харьяалагдах байгууллагуудаар дамжуулан 964.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

1420050055

Аудитын гол асуудал

Тайлант онд 5,526.9 сая төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд нэг удаа тодотгол хийж, 10.2 хувиар нэмэгдүүлж, нийт 6,155.3 сая төгрөгөөр баталжээ. Үйл ажиллагаандаа 4,919.0 сая төгрөгийн төсөв зарцуулсан нь өмнөх онтой харьцуулахад 9.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Бусад асуудал

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 100.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР




Г.НАНДИНЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
30	ХӨРӨНГӨ	4		
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ			
33	АВЛАГА	5	-	20,239,300.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага		-	20,239,300.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6	99,727,880.18	49,408,925.18
35400	Хангамжийн материал		41,900,000.00	19,400,000.00
35410	Бичиг хэргийн материал		1,795,300.00	47,000.00
35420	Аж ахуйн материал		5,658,900.00	4,845,000.00
35440	Түлш, шатах тослох материал		3,459,193.18	1,797,497.18
35470	Бусад хангамжийн материал		46,914,487.00	23,319,428.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)		99,727,880.18	69,648,225.18
39200	Биет хөрөнгө	-	434,913,240.93	342,711,210.34
39203	Авто-тээврийн хэрэгсэл		87,000,000.00	87,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл		(29,725,000.00)	(38,425,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)		600,377,935.00	502,091,445.00
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж		(302,499,288.41)	(273,699,688.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		197,722,514.00	162,432,175.00
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга		(117,962,919.66)	(96,687,721.30)
39300	Биет бус хөрөнгө	-	0.00	4,990,000.00
39301	Программ хангамж		990,000.00	990,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Программ хангамж		(990,000.00)	(990,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө		5,016,252.42	4,990,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл - Бусад биет бус хөрөнгө		(5,016,252.42)	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	-	434,913,240.93	347,701,210.34
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	-	534,641,121.11	417,349,435.53
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9	-	48,370,000.00
41300	Өглөг	-	-	48,370,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг		-	48,370,000.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)		-	48,370,000.00
5	Цэвэр хөрөнгө /өмч		534,641,121.11	368,979,435.53
51	Засгийн газрын хувь оролцоо		534,641,121.11	368,979,435.53
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/орон нутгийн сан		120,025,885.00	120,025,885.00
51200	Хуримтлагдсан үр дүн		414,615,236.11	248,953,550.53
51210	Өмнөх үеийн үр дүн		327,873,466.39	414,615,236.11

Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51220	Тайлант үеийн үр дүн		86,741,769.72	(165,661,685.58)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү			
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)		534,641,121.11	368,979,435.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	-	534,641,121.11	417,349,435.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	144,266,494.00	463,304.00
1200	Нийтлэг татварын бус орлого		144,266,494.00	463,304.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		143,275,990.00	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал		990,504.00	463,304.00
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		5,317,949,425.04	5,342,233,145.43
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		884,964,036.00	423,279,000.00
131104	Дээд шатны төсвийн эрх захирагчаас олгосон санхүүжилт		433,000,000.00	261,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		451,964,036.00	162,279,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		4,432,985,389.04	4,918,954,145.43
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		4,432,985,389.04	4,918,954,145.43
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	5,462,215,919.04	5,342,696,449.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	5,375,474,149.32	5,508,358,135.01
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,904,603,774.32	4,935,115,135.01
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		1,621,126,680.58	2,001,532,021.34
210101	Үндсэн цалин		459,198,215.06	571,357,988.93
210102	Нэмэгдэл		303,430,735.04	276,209,836.67
210103	Унаа хоолны Хөнгөлөлт		127,788,482.00	212,049,487.00
210104	Урамшуулал		730,709,248.48	941,914,708.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		192,340,365.25	236,432,398.09
210201	Тэтгэврийн даатгал		120,312,781.06	170,949,845.90
210202	Тэтгэмжийн даатгал		17,413,870.08	16,159,635.61
210203	ҮОМШӨ-ний даатгал		8,773,234.29	6,234,042.41
210204	Ажилгүйдлийн даатгал		8,657,236.00	5,482,027.74
210205	Эрүүл мэндийн даатгал		37,183,243.82	37,606,846.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		16,633,000.00	-
210304	Байрны түрээс		16,633,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал		78,297,749.14	76,303,612.00
210401	Бичиг хэрэг		33,224,279.00	30,534,267.00
210402	Тээвэр, шатахуун		33,575,255.11	17,295,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		11,373,215.03	11,121,586.00

Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		-	900,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		125,000.00	
210408	Бараа материал акталсны зардал		-	16,452,759.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		10,181,200.00	8,938,894.00
210604	Урсгал засвар		10,181,200.00	8,938,894.00
2107	Томилолт, зочны зардал		337,001,784.00	254,638,519.00
210701	Гадаад албан томилолт		287,804,284.00	174,816,448.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		49,197,500.00	79,822,071.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		603,539,223.18	1,123,957,580.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		600,608,148.00	1,119,142,700.00
210803	Даатгалын үйлчилгээ		329,100.00	1,596,000.00
210804	Тээврийн хэрэгсэлийн татвар		69,776.00	247,528.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		2,532,199.18	2,971,352.00
210807	Газрын төлбөр		-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,045,483,772.17	1,233,312,110.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		928,016,511.00	1,093,245,980.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол		117,467,261.17	140,066,130.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,470,870,375.00	573,243,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,018,906,339.00	410,964,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		251,200,000.00	56,970,000.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		32,893,339.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		734,813,000.00	353,994,000.00
2134	Орон нутгийн төвсийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		451,964,036.00	162,279,000.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		451,964,036.00	162,279,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ			
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	3	86,741,769.72	(165,661,685.58)
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)			
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО			
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)			
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)			
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)		86,741,769.72	(165,661,685.58)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,317,949,425.04	5,342,233,145.43
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	884,964,036.00	423,279,000.00
131104	Дээд шатны төсвийн эрх захирагчаас олгосон санхүүжилт	433,000,000.00	261,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	451,964,036.00	162,279,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,432,985,389.04	4,918,954,145.43
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага	4,432,985,389.04	4,918,954,145.43
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,317,949,425.04	5,342,233,145.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,203,353,435.04	5,290,379,045.43
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,725,230,593.04	4,717,136,045.43
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,621,126,680.58	2,001,532,021.34
210101	Үндсэн цалин	459,198,215.06	571,357,988.93
210102	Нэмэгдэл	303,430,735.04	276,209,836.67
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	127,788,482.00	212,049,487.00
210104	Урамшуулал	730,709,248.48	941,914,708.74
210105	Гэрээт ажлын цалин		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	192,340,365.25	236,432,398.09
210201	Тэтгэврийн даатгал	120,312,781.06	170,949,845.90
210202	Тэтгэмжийн даатгал	17,413,870.08	16,159,635.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,773,234.29	6,234,042.41
210204	Ажилгүйдлийн даатгал	8,657,236.00	5,482,027.74
210205	Эрүүл мэндийн даатгал	37,183,243.82	37,606,846.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,633,000.00	-
210304	Байрны түрээс	16,633,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	108,433,668.03	65,542,208.00
210401	Бичиг хэрэг	20,855,130.00	11,370,970.00
210402	Тээвэр, шатахуун	33,000,000.00	13,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,373,215.03	11,121,586.00
210404	Ном, хэвлэл	7,495,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	35,710,323.00	29,149,652.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,542,200.00	11,288,894.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,350,000.00
210604	Урсгал засвар	13,542,200.00	8,938,894.00
2107	Томилолт, зочны зардал	344,564,884.00	254,638,519.00
210701	Гадаад албан томилолт	287,950,284.00	174,816,448.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	56,614,600.00	79,822,071.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,012,649,669.18	1,508,617,653.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,009,718,594.00	1,503,220,773.00

Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	329,100.00	1,596,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,776.00	247,528.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,532,199.18	3,553,352.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	415,940,126.00	639,084,352.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	415,940,126.00	639,084,352.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,478,122,842.00	573,243,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,026,158,806.00	410,964,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	258,452,467.00	56,970,000.00
213207	Тэтгэвэр гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,893,339.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	734,813,000.00	353,994,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	451,964,036.00	162,279,000.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	451,964,036.00	162,279,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	5,203,353,435.04	5,290,379,045.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	114,595,990.00	51,854,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	114,595,990.00	51,854,100.00
223	Бусад хөрөнгө	114,595,990.00	51,854,100.00
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	114,595,990.00	51,854,100.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	114,595,990.00	51,854,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(114,595,990.00)	(51,854,100.00)
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)		
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			327,873,466.39	327,873,466.39
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	120,025,885.00		327,873,466.39	447,899,351.39
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				-
6	Тайлант үеийн үр дүн			86,741,769.72	86,741,769.72
7	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	120,025,885.00		414,615,236.11	534,641,121.11
8	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	120,025,885.00		414,615,236.11	534,641,121.11
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	120,025,885.00			120,025,885.00
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				-
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз				-
14	Өмчид гарсан өөрчлөлт				-
15	Зарласан ноогдол ашиг				-
16	Тайлант үеийн үр дүн			(165,661,685.58)	(165,661,685.58)
27	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	120,025,885.00		248,953,550.53	368,979,435.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тайлан он		Зөрүү	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Дүнгээр	Хувиар
12	Татварын бус орлого	6,155,339,900.00	4,918,954,145.43	1,236,385,754.57	79.9
122	Тусламж, санхүүжилтийн орлого	6,155,339,900.00	4,918,954,145.43	1,236,385,754.57	79.9
122005	Төсвөөс санхүүжих	6,155,339,900.00	4,918,954,145.43	1,236,385,754.57	79.9
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,155,339,850.00	4,918,954,145.43	1,236,385,704.57	79.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,155,339,850.00	4,918,954,145.43	1,236,385,704.57	79.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,662,084,850.00	4,548,990,145.43	1,113,094,704.57	80.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,041,485,600.00	2,001,532,021.34	39,953,578.66	98.0
210101	Үндсэн цалин	539,100,000.00	571,357,988.93	(32,257,988.93)	106.0
210102	Нэмэгдэл	302,551,600.00	276,209,836.67	26,341,763.33	91.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	236,918,000.00	212,049,487.00	24,868,513.00	89.5
210104	Урамшуулал	962,916,000.00	941,914,708.74	21,001,291.26	97.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд шимтгэл төлөх	255,185,150.00	236,432,398.09	18,752,751.91	92.7
210201	Тэтгэврийн даатгал	173,526,100.00	170,949,845.90	2,576,254.10	98.5
210202	Тэтгэмжийн даатгал	20,414,800.00	16,159,635.61	4,255,164.39	79.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,207,100.00	6,234,042.41	3,973,057.59	61.1
210204	Ажилгүйдлийн даатгал	10,207,150.00	5,482,027.74	4,725,122.26	53.7
210205	Эрүүл мэндийн даатгал	40,830,000.00	37,606,846.43	3,223,153.57	92.1
2103	Байр ашиглалттай холбоотой зардал тогтмол	20,160,000.00	-	20,160,000.00	-
210304	Байрны түрээс	20,160,000.00	-	20,160,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	163,246,600.00	65,542,208.00	97,704,392.00	40.1
210401	Бичиг хэрэг	13,066,600.00	11,370,970.00	1,695,630.00	87.0
210402	Тээвэр, шатахуун	42,000,000.00	13,900,000.00	28,100,000.00	33.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,180,000.00	11,121,586.00	7,058,414.00	61.2
210404	Ном, хэвлэл	30,000,000.00	-	30,000,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60,000,000.00	29,149,652.00	30,850,348.00	48.6
2106	Эд хогшил, урсгал зардал засварын	140,000,000.00	51,727,994.00	88,272,006.00	36.9
210601	Багаж, техник хэрэгсэл	55,750,000.00	35,159,600.00	20,590,400.00	63.1
210602	Тавилга	74,250,000.00	7,629,500.00	66,620,500.00	10.3
210604	Урсгал засвар	10,000,000.00	8,938,894.00	1,061,106.00	89.4

Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	300,000,000.00	254,638,519.00	45,361,481.00	84.9
210701	Гадаад албан томилолт	200,000,000.00	174,816,448.00	25,183,552.00	87.4
210702	Дотоод албан томилолт	20,000,000.00	-	20,000,000.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	80,000,000.00	79,822,071.00	177,929.00	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	2,015,707,500.00	1,300,032,653.00	715,674,847.00	64.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,963,107,500.00	1,290,645,773.00	672,461,727.00	65.7
210803	Даатгалын үйлчилгээ	2,000,000.00	1,596,000.00	404,000.00	79.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	247,528.00	252,472.00	49.5
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	-	100,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	50,000,000.00	7,543,352.00	42,456,648.00	15.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	726,300,000.00	639,084,352.00	87,215,648.00	88.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	726,300,000.00	639,084,352.00	87,215,648.00	88.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	493,255,000.00	369,964,000.00	123,291,000.00	75.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	82,000,000.00	-	82,000,000.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	82,000,000.00	-	82,000,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	411,255,000.00	369,964,000.00	41,291,000.00	90.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,255,000.00	15,970,000.00	5,285,000.00	75.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	390,000,000.00	-	390,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	353,994,000.00	(353,994,000.00)	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тайлан он
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	423,279,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	261,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	220,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	220,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	220,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	41,000,000.00
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	162,279,000.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	162,279,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	423,279,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	423,279,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	261,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	162,279,000.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 147,315.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 674,308.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 1,292.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 557,095.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 115,921.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Видео шторк, контент, шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.	1	135,900.0	1	135,900.0			1	135,900.0				
Төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг дутуу тайлагнасан байна.	1	7,425.0			1	7,425.0	1	7,425.0				
Мөнгөн гүйлгээний тайланд биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг дутуу тайлагнасан байна.	1	3,990.0			1	3,990.0	1	3,990.0				
Дүн	3	147,315.0	1	135,900.0	2	11,415.0	3	147,315.0				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Гадаад албан томилолтын урьдчилгаа авагчийн гаргасан гүйцэтгэл, олгосон урьдчилгааг холбогдох анхан шатны баримттай харьцуулан мөнгөн урьдчилгааны тайлан бэлтгээгүй байна.	1	115,921.0					1	115,921.0				
Нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтэрсэн бараа, ажил, үйлчилгээнд шууд гэрээ байгуулсан байна.	1	285,778.5			1	285,778.5						

Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бараа ажил үйлчилгээнд зарцуулсан ажил гүйлгээний гүйцэтгэлийн анхан шатны баримт хангалтгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.	1	271,317.0			1	271,317.0						
Гадаад албан томилолтоор ажилласан албан хаагчийн хоолны мөнгийг давхардуулж илүү тооцож олгосон байна.	1	1,292.0	1	1,292.0								
Дүн	4	674,308.5	1	1,292.0	2	557,095.5	1	115,921.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил												
Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг долоо хоногийн дотор мэдээлэхээс 1,454,867.8 мянган төгрөгийн 108, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 303,153.1 мянган төгрөгийн орлогын 6, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 491,024.5 мянган төгрөгийн зарлагын 32, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 918,601.9 мянган төгрөгийн 63 шийдвэрийг хугацаанд нь тус тус мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 53, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 101, төсөв,	1	3,167,647.3			1	3,167,647.3						

Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 133 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.												
Дүн	1	3,167,647.3			1	3,167,647.3						
Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой зөрчил												
Төлөөлөгчдийн чадавхжуулах арга хэмжээний зардалтай давхардуулж гадаад томилолт, дэмжлэг олгосон байна.	1	285,463.5			1	285,463.5						
Зөвлөлийн гишүүдэд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгосон байна.	1	855,036.0			1	855,036.0						
Албан хаагчдад мөнгөн урамшуулал, цалинг давхардуулж олгосон байна.	1	25,721.5			1	25,721.5						
Өмч хамгаалах ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс давхардуулж урамшуулал олгосон байна.	1	19,791.4			1	19,791.4						
Шүүхийн шийдвэрийн дагуу ажилтны ажилгүй байсан хугацааны нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төсвөөс төлж зардлаар тайлагнасан байна.	1	4,683.3			1	4,683.3						
Дүн	5	1,190,695.7			5	1,190,695.7						
Нийт дүн	6	4,358,343.0			6	4,358,343.0						

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		